

Мэдээлэх Хуудас Хурдны Камер

Хурдны камер гэж юу вэ?

Хурдны камер нь радар ашиглан хурдны дээд хязгаараас илүү хурдтай явж буй машинуудыг хянаж торгууль өгдөг.

- Арлингтоны цагдаа дүрс бичлэгийг хянан хурд хэтрүүлсэн эсэхийг баталгаажуулна. Тэгээд шуудангаар торгууль явуулдаг.

Хурдны камерийг ямар зориулалтаар ашигладаг вэ?

Хурдны дээд хязгаарыг мөрдүүлэх замаар амь насанд аюултай эсвэл ноцтой ослыг бууруулах.

- [CDC](#) -н тооцоогоор хурдны камерууд нь замын ослыг 50% хүртэлх хувиар бууруулдаг байна.
- [Тээврийн Аюулгүй Байдлын Үндэсний Зөвлөлөөс](#) хурдны камеруудыг хурд бууруулахад үр дүн өндөртэй гэж үздэг.

Хурдны камер Арлингтон ямар тус хүргэдэг вэ?




Бид хүний амь аврахын тулд хурдаа багасгах ёстой.

- Машины хурд нэмэгдэх тусам бэртэж гэмтэх, хүний амь нас хохирох эрсдэл нэмэгддэг.
- Арлингтонд гардаг дөрвөн ослын нэг нь хурд хэтрүүлсэнтэй холбоотой байдаг.
- Арлингтоны [Тэг Зорилт Тээврийн Аюулгүй Байдлын Мөрийн Хөтөлбөрт](#) хурдны камерыг хурд бууруулах хэрэгсэл гэж тодорхойлсон байдаг.
- Арлингтоны [Цагдан Сэргийлэхийн Ажлын Бүлэг](#) нь мөн хурдны камерийг төвийг сахисан шийдвэр гаргахад хэрэгтэй зүйл гэж зөвлөдөг.
- 2020 онд Виржиниад муж болон орон нутгийн цагдааг [сургууль, ажлын бүсэд](#) хурдны камер ашиглах [хуулийг](#) баталсан.
- Хурдны камер ойрхон байгааг жолооч нарт мэдэгдэх анхааруулах тэмдгийг урьдчилан байрлуулах ёстой.
- Машины эзэнд \$50-н торгууль тавина. Машины эзний жолооны үнэмлэхэд оноо нэмэхгүй. Хурдны камерийн торгуулийг даатгалд ашигладаггүй.



Вашингтон, Керкланд дахь сургуулийн бүсэд хурдны камер байгааг анхааруулах тэмдэг. Эх сурвалж: [kirklandwa.gov](#).

МАШИНД МӨРГҮҮЛЭХ



Хурд нэмэгдэх тусам, нас баралт нэмэгддэгийг харуулсан график. Эх сурвалж: Сээтл хотын Тэг Зорилтын Мөрийн Хөтөлбөр, хуудас 12.

Хурдны камерууд Арлингтоны гудамжинд хэзээ тавигдах вэ?

2022-2023 оны Өвлөөс Арлингтоны сургууль, ажлын бүсүүдээр тавигдаж эхлэнэ.